



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/410

Хэрлэн сум

Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн
4 дүгээр уулзалтад зориулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны 8 дугаар сарын 13-аас 2022 оны 8 дугаар сарын 14-ний хооронд Цэнхэрмандал сумын “Хөх нуур”-т зохион байгуулагдаж буй Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн 4 дүгээр уулзалтад зориулж 2,808,400 (хоёр сая найн зуун найман мянга дөрвөн зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010937

Аймгийн Засаг даргын 2022
оны 28 дугаар сарын 29-ны
А/418 захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Уран бүтээлчид урамшуулал	25	50,000	1,250,000
2	Шатахуун (а-92)	70	2,520	176,400
4	Шатахуун (дт)	260	4,030	1,047,800
5	Хэвийн боов	25	3,500	87,500
6	Еэвэн	1	21,700	21,700
7	Ааруул	5	15,000	75,000
8	Ламын зэд	3	50,000	150,000
	Дүн			2,808,400